



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/53

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б”, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Аргачлал шинэчлэн батлах тухай” тогтоол, 2016 оны 208 дугаар тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний” 1.1.3.5 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн индексийг тооцох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

А.Эрдэнэгэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Мөнхтөр

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Д.Гүндэгмаа

-Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

С.Отгонжаргал

-Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Б.Саранчимэг

-Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

П.Эрдэнэсайхан

-Орон нутгийн өмчийн газрын дарга

Я.Мөрөн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Эдийн засагч, хөрөнгө оруулалтын тооцоолол хариуцсан ахлах мэргэжилтэн

-Сумдын Засаг дарга

C:\users\albanbichig2021\zahiramjA4.docx

430900075

2. Сумдад орон нутгийн хөгжлийн индексийг тооцох дэд ажлын хэсгийг байгуулж ажиллахыг Сумдын Засаг дарга нар, орон нутгийн хөгжлийн индексийг батлагдсан хүснэгтийн дагуу гаргаж, баталгаажуулж, үр дүнг Үндэсний хөгжлийн газарт мэдээлж ажиллахыг /А.Эрдэнэгэрэл/-д даалгасугай.

3. Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлж, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахин, ариутгал халдваргүйжүүллийг хийж, хүн хоорондын зай барьж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ